

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-7

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал 4-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Номин, Ц.Туваан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр, Т.Доржханд, С.Зулпхар, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар;

Тасалсан: Э.Болормаа, Э.Одбаяр.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүнээс 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүнээс 2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ч.Лодойсамбуу нар үг хэлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул хариулав.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 13
Бүгд: 17
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 17 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн, Аюушийн Ариунзаяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жудагийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлъе. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалтдаа бэлдье. Анхааралтай байгаарай гишүүдээ.

Засгийн газраас 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжъе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хэний тоног. Энхтуяа гишүүн горимын санал гаргах уу? Тийм байна, орчихсон байгаа. Тэгэхдээ таны санал эсрэг гарчихлаа, тийм. Та саяын санал хураалтад. Энхтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтуяа: Сайн байцгаана уу. Горимын санал гаргаж байна. Энэ Гэр бүлийн тухай хууль сая өргөн баригдсан байгаа. Тэгэхээр энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Тийм үү, тэгвэл саяын санал хураалт явагдсан байна. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Энхтуяа гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар санал, Энхтуяа гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг намрын чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ, санал хураалтдаа ороогүй улсууд бэлдээрэй санал хураалтад. Санал хураалт. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газраас 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүнээс 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжсэнгүй. Горимын саналтай хүн байна уу? Горимын санал гаргах хүн байна уу? Ухамсартайгаар эсрэг санал өгч байгаа юм байна тийм үү? Горимын санал гаргах хүн байхгүй юу? Тэгвэл 17 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 47,1 хувиар Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Бадамсүрэн нарын гишүүний гаргасан хуулийн төсөл намрын чуулганд орохыг дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүнээс 2025 оны 11 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Энэ нөгөө Ардчилсан намын бүлэг завсарлага аваад, Их Хурлын даргатай холбоотой асуудал дээр байх тийм ээ. Их Хурлын дарга нам бус байх ёстой, намын гишүүн биш байх ёстой, түдгэлзэх ёстой гэсэн хуулийн төсөл гэж ойлгож байна тэр мөн үү? Энийг чинь тэгээд Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль гээд олон хууль зөрчөөд өргөн мэдүүлээгүй гэж ойлгож байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүн

хуулийн төсөл санаачилсан бол түүний бүрдлийг Тамгын газар хянах ёстой, шаардлага хангасан эсэхийг нь нягтлах ёстой, энэ процесс явагдаагүй.

Дээрээс нь тов тогтоолгох бичгээ Улсын Их Хурлын даргад хүргүүлэх ёстой, тэрүүгээр нь албан ёсоор тов тогтоож, бас нэг ёс төртэй өргөн мэдүүлдэг энэ процесс хийгдээгүй. Чуулганы хуралдаан даргалагч Бат-Эрдэнэ даргад завсарлагын хугацаа дууссан гэж байгаад л аваачаад өгч байх шиг харагдсан нэг цаас. Монголын төр чинь төртэй, төр төмбөгөр ёс, ёмбогор байх ёстой. Энэ Хууль тогтоомжийн тухай хууль, Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль гээд олон хуулийг зөрчөөд ийм байдлаар хуулийн төслийг өргөн барьж байгаа нэртэй хуралдаан даргалагчид нэг цаас аваачиж өгөөд, тэрийг нь Их Хурал хэлэлцээд явдаг болох юм бол цаашдаа буруу жишиг тогтоно. Буруу жишиг.

Тийм болохоор энэ асуудлыг өргөн барих процессыг нь гүйцээх ёстой, Хууль тогтоомжийн тухай хууль болон Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан тов тогтоолгох, тов тогтоохын өмнө хууль, тогтоолын төсөл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шаардлага бүрдэл нь шаардлага хангаж байгаа эсэх энэ бүгдийг нягталж байж өргөн барьдаг ийм дэгээрээ явахгүй бол энэ зарчмаа барьж явахгүй бол цаашдаа буруу жишиг тогтоно. Тийм болохоор энийг санал хураалгах шаардлагагүй. Шаардлагагүй. Төр төмбөгөр ёс ёмбогор доо. Төрийн ажил явах өөрийн гэсэн дэг жаягтай, тэр дэг жаягийнхаа дагуу явах ёстой.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагч Лодойсамбуу гишүүн, Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Төрийн ажил зүйр үгээр явахгүй, эрх зүй, хуулиар явна. Хуулиараа сая Тамгын газар бүрдлийг нь шалгаад, бүх зүйл ном журмынх нь дагуу яваад, өргөн барьсан асуудал байгаа. Яг Их Хурлын даргын тэр өрөөнд өргөн барина гэдэг хуулийн зохицуулалт байхгүй 1-д.

2-т олон нийтийн саналыг авсангүй гэдэг жишээлбэл шүүмжийг зарим нь хэлэх байх. Энэ Их Хурлын дотоод үйл ажиллагаа учраас Хууль тогтоомжийн хуулиараа зарим тэр шатууд алгасагддаг. Тэгэхээр энд ямар нэгэн хууль зөрчсөн, хуулийг алгассан, төрийг үл хүндэтгэсэн ийм зүйл байхгүй. Тэгэхээрээ одоо яах вэ Даргын дэргэдэх зөвлөл дээр ярьсан юм, энийгээ өргөн бариад, энийгээ хэлэлцээд ингээд явчихъя. Тэрнээс биш өргөн барих дээр нь болиулаад ч гэдэг юм уу, гишүүдийн хууль санаачлах эрхэд янз янзын байдлаар халдаад ч гэдэг юм уу байдлаар яваад хэрэггүй гэж. Тэгээд одоо Байнгын хороод орж ирж байна. Байнгын хороон дээр санал хураагаад унавал намрын чуулганаар хэлэлцэх асуудал дотор багтахгүй. Энэ одоо заавал багтаа гэж бүгдийг нь дэмж гэдэг ийм чиглэл хэн ч өгөх эрхгүй.

Тэгэхээрээ ном журмаараа явж байгаа юман дээр хэдүүлээ төрийн нэр барихгүйгээр, зарчмаа бариад явсан нь дээр байх. Саналаа хураагаад, дэмжвэл дэмжээд, унагаавал унагаагаад ингээд явна. Үндсэндээ хамгийн гол санаа бид ямар зарчимтай өргөн барьсан бэ гэхээр Монгол Улсын парламент, Монгол Улсын парламент Монгол Улсын Их Хурлын дарга бол нэг намын дарга байж болохгүй л гэсэн. Энэ бол Монгол хэлээр үг ойлгодог хүн болгоны толгойд маш ойлгомжтой сонсогдож байгаа, зарчмын байр суурь. Тэгэхээр энэ хуулиа ийм санаатайгаар хуулийн төсөл санаачлаад, хамтраад өргөн барих нь гишүүдийн бүрэн эрх. Энийг хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юү, хэлэлцээд батлах уу, үгүй юү гэдгээ шийдэх нь

парламентын бүтэц, Байнгын хороо, Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Тэгэхээр саналаа хураая.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүний хэлсэн санал дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Хатантуул зөвлөх нэг тайлбар хэлээдэх дээ. Хуулийн материал бүрдүүлбэр хэрхэн, яаж хангагдсан юм бэ гэдэг талаар, микрофон. Энэ юу гэх юм бэ ажлын хэсэг биш, тэнд очих ёстой юм уу, наана чинь асаж байна. Микрофон ассан байна.

Б.Хатантуул: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн албан бичгээр 2025 оны 11 сарын 18-ны өдөр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов тогтоох тухай албан бичгээ ирүүлсний дагуу 11 сарын 18-нд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс бүрдүүлбэр хянасан хяналтын хуудсыг хавсаргасан байна. Үүний дагуу Улсын Их Хурлын дэд дарга Бат-Эрдэнэд хуулийн төслийг өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын дарга Бат-Эрдэнээс 25 оны 11 сарын 20-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд цохолт хийгдсэн байна.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр бүрдүүлбэр хангасан байна гэж үзсэн үү?

Б.Хатантуул: Хангасан.

Ц.Сандаг-Очир: Ингээд Тэмүүжин нарын гишүүний Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хуулийн холбогдох бүрдүүлбэр хангасан байна гэж үзэж байна. Ийм учраас намрын ээлжит чуулганд хэлэлцэх эсэхийг шийдэх санал хураалт явуулна. Гишүүд хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 23,5 хувиар санал дэмжигдсэнгүй. Тэгэхээр уг хуулийг намрын чуулганы хэлэлцэх асуудалд багтсангүй. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

15.32 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа та бүхэнд. Одоо шууд чуулгандаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА